

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГИЙН БАГШИЙН АЖЛЫН БАЙРНЫ СУДАЛГАА

А.Оюунбилэг
МУБИС-ийн СӨБК

Хураангуй

СӨБ-ын байгууллагын багшлах боловсон хүчний ажлын ачаалал, хөгжлийн үйл явц хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулж буй хугацааны талаар практик судалгаа хийж тайлбар өгөхийг зорилоо. Судалгаанд СӨБК-ын зэрэглэл ахиулах курст суралцаж буй 16 аймаг, хотын 54 гаруй багш хамрагдсан. Судалгаа нь статистик судалгаа биш бөгөөд СӨБ-ын багшийн /цаашид багшийн гэх/ ажлын байрны үйл ажиллагааны хандлагын мэдээлэлд тулгуурлан үнэлж цаашид үйл ажиллагааг оновчтой зохион байгуулахад чиглэсэн судалгаа шинжилгээний сэдэл үүсгэхийг эрмэлзсэн болно.

Судалгааны явцад цуглуулсан мэдээ баримт, судалгаа, үнэлгээ дүгнэлтээс багшийн ажлын ачаалал, баримт материал бүрдүүлэх, боловсруулах, бусад техник ажиллагаа, дээрээс ирэх хяналт шалгалт ихээх, ихэнх цагийг хүүхэд хөгжүүлэхэд бус өөр ажилд зарцуулагдаж байна гэсэн дүгнэлт хийж байна.

Түлхүүр үг:

СӨБ-ын байгууллагын багшийн ажлын байр, багшийн хөгжил, хүүхдийн хөгжил, ажлын ачаалал.

Удиртгал

Бага насны хүүхдийг хөгжүүлэхэд тэднийг өөрсдөөр нь хийлгэх, мэдрэхүйн эрхтэн, гар хуруугаар нь тэмтрүүлж мэдрүүлэх арга чухал учир хөгжиж, сурч боловсрох таатай орчныг бүрдүүлэх /үйл ажиллагааг төлөвлөж явуулах/ асуудалд багш нарын санал санаачлага, цаг хугацаа илүү их шаардлагатай бөгөөд одоогийн байдлаар бодит боломж муу байгаа нь нууц биш юм. Хүүхэд хөгжүүлэх тал дээр илүү түлхүү ажиллах, цаг хугацаа, онол арга зүй, багшийн ажлыг оновчтой удирдах менежментийг боловсронгуй болгох асуудлуудыг шинжлэх ухааны үндэстэй бодитой шийдэх шаардлагатай байгаа нь боловсролын шинжлэлийн нэн чухал зорил болж билээ.

Судалгаанд дараах зорилтыг тавьж ажиглалт, ярилцлага, асуулга, баримт бичиг судлах аргуудыг ашиглав. Үүнд:

- СӨБ-ын байгууллагын багшийн ажлын байранд дүн шинжилгээ хийх.
- СӨБ-ын байгууллагын багшлах боловсон хүчний ажлын ачааллыг судалж тодорхойлох.

1. Боловсролын байгууллагын гол хүч болсон багшлах боловсон хүчний талаар зарим статистик мэдээг орууллаа.

СӨБ-ын салбарт олсон ололт амжилт манай орны түүхэн хөгжлийн явцад хангалттай их ч дэлхийн глобал хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн сургалтын технологийг улам боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага зүй ёсоор гарч байна. Өнгөрсөн хугацаанд СӨБ-ын талаар төрөөс явуулсан бодлогын нэг хэсэг нь боловсролын хүртээмж, хамрах хүрээг нэмэгдүүлэх үйл ажиллагаа байсан бөгөөд одоогийн байдлаар нийт сургуулийн өмнөх насны хүүхдийн 45 гаруй хувь нь хамрагдаад байна.

2004-2005 оны хичээлийн жилд улсын хэмжээнд 687 цэцэрлэг ажиллаж байгаагаас улсын 637, байгууллагын 25, хувийн 25 цэцэрлэг ажиллаж нийт 82674 хүүхэд хамрагдаж буй статистик мэдээ гарсан байна.

Цаашид хамрах хүрээ, хүртээмжийн асуудлыг анхаарахаас гадна үйл ажиллагаанд чанартахыг гаргах, нэг багшид ногдох хүүхдийн тоог норм хэмжээнд байлгах шаардлага нийгмийн хөгжлийн дагуу гарч байна.

Цэцэрлэгийн нэг багшид ногдох хүүхэд 1995-1996 онд дунджаар 31,5 байсан бол 1999-2000 онд 26,3; 2004-2005 онд 27,5 болж буурсан нь сайн талтай боловч хот хөдөөд харилцан адилгүй байна.

Нэг багшид ногдох хүүхдийн тоо бага байх нь боловсролын чанар үр ашгийг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж буйг дэлхийн хүний хөгжлийн илтгэлд заасан байдаг./2/

Хүснэгт 1.

	Бүх цэцэрлэг	Улсын	Байгууллагын	Хувь	Нийт бүлэг	Нэг хүнд ноогдох хүүхэд	Нийт хамрагдсан хүүхэд	Хувилбар /сур/ хамрагдсан хүүхэд
Улсын хэмжээнд	687	637	25	25	3006	27,5	82674	24386

Глобалчлалын үйл явц хүнээ дэлхийн түвшинд хүргэж хөгжүүлэх мөн хүний хөгжилд шинэ үзэл баримтлалаар хандахыг зүй ёсоорг шаардаж байгаа өнөө үед хүүхдийн хөгжилд илүү шинжлэх ухаанчаар хандах хэрэгтэй болж байна.

Үүнд багшийн үүрэг их бөгөөд багш нарын авьяас чадварыг нээн илрүүлэх тэдний зорилгыг нэгтгэж, шинэ сэтгэлгээ арга барилаар хүүхдийг хөгжүүлэх үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах, хөгжсөн багшийг төрүүлэхийг эрхэмлэх нь юунаас ч чухал билээ.

2004-2005 оны хичээлийн жилд СӨБ-ын байгууллагад нийт 687 эрхлэгч, 3033 багш 115 арга зүйч 276 дуу хөгжмийн багш ажиллаж байна.

Хүснэгт 2.

	Нийт ажиллагсад	Эрхлэгч	Үндсэн багш	Багш	Арга зүйч	Дуу хөгжмийн багш	Туслах багш
Улсын хэмжээнд	10948	687	3424	3033	115	276	2856

Цаг үеэ даган урган гарсан багшийн хөгжлийн шинэ хэрэгцээ шаардлагыг мэдрэмжтэй хүлээн авч бүх шатны боловсролын байгууллага оновчтой ажил зохион явуулах хэрэгтэй болж байна.

Багшийг хөгжүүлэх нь хүний, материалын, санхүүгийн, цаг хугацааны нөөцийг шаарддаг бөгөөд багш хөгжихөд хувь багш өөрийгөө өөрчлөх бүхий л боломжоо ашиглан мэргэжил, мэргэшил, боловсролоо байнга дээшлүүлж, цаг ямагт өсөн хөгжих идэвхитэй хандлага, оролцоо хүсэл тэмүүлэлтэй байх нь чухал гэдгийг тодорхойлох боллоо. /3/

Багшийг хөгжүүлэх ойрын болон хэтийн эрэлт хэрэгцээг нарийн тодорхойлж, олон хувилбар, арга зам, санхүүгийн эх үүсвэрээр бүх түвшний сургалтыг оновчтой зорилго, зохион байгуулалтай явуулах ажил хийгдэж байна,

Одоогийн байдлаар СӨБК болон бусад их дээд сургуулиуд дээр баклавр, магистрантурт суралцагчид жил ирэх тусам нэмэгдснээр багш боловсон хүчний бүрэлдэхүүн дээшилж байна.

Орчин үеийн багшийн хөгжлийн бүтэцжсэн хүрээг эрдэмтэд дараах байдлаар тодорхойлж байна /5/. ЭНЭ НЬ СӨБ-ын байгууллагын багшийн хөгжилд мөн хамааралтай бөгөөд хувь багш, хамт олон хөгжиж , чадваржснаар хүүхдийн эрүүл мэнд, хөгжил, төлөвшил сайжрах нь дамжиггүй.

2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багшийн ажлын байрны тодорхойлолт:

Цэцэрлэгийн багшийн ажлын байрны тодорхойлолтыг БСШУ-ны сайдын 2001 оны 173ртушаалын 2-р хавсралтаар баталсан байдаг. Үүнд цэцэрлэгийн багшийн ажлын байрны зорилгыг тодорхойлохдоо:


СӨНХ-ийг хөгжүүлэх, төлөвшүүлэх, суралцах үйл явцыг шинжлэх ухааны үндэслэлтэй удирдан чиглүүлэх, СӨБ-ын стандартыг эзэмшүүлэн, сургалт хүмүүжлийн ажлын чанар, үр ашгийг дээшлүүлэхэд энэхүү ажлын байрны зорилго оршино.

Схем №1.



- Ажлын байрны тодорхойлолтонд 4 үндсэн чиглэлээр үйл ажиллагааг томьёолсон байна.

Схем 2.



- Үндсэн үүргүүдийн хүрээнд ажлын байранд хийгдэх ажлуудыг 5 үндсэн бүлэгт хуваан нарийвчлан заасан байна.

Схем №3.



- СӨБ-ын байгууллагын багшийн үйл ажиллагааг дараах хэсгүүдэд хувааж ангилсан байна.

Схем №4.



Эндээс харахад багшийн хийх ажиллагааны цар хүрээ их байгаа нь харагдаж байна.

Судалгааны үр дүн

Судалгааны зорилго:

Багшийн ажлын байранд нөлөөлөх зарим хүчин зүйлийг судалж дүгнэлт хийхэд оршино.

Судалгааны объект:

Судалгаанд дараах 16 аймаг, хотын багш нар хамрагдсан.

Хүснэгт 3.

Аймаг, хот	Хамрагдсан хүний тоо
1. Архангай	3
2. Багануур	2
3. Булган	5
4. Баян-Өлгий	4
5. Дархан	8
6. Дорнод	1
7. Завхан	3
8. Орхон	3
9. Өвөрхангай	4
10. Өмнөговь	1
11. Сэлэнгэ	1
12. Увс	3
13. Ховд	2
14. Хөвсгөл	1
15. Хэнтий	1
16. Улаанбаатар	12
17. Бүгд	54

Судалгаанд хамрагдсан хүний ажилласан жилийг авч үзвэл:

Хүснэгт 4.

Ажилласан жил	Хүний тоо
1-5 жил	11
5-10 жил	11
10-15 жил	39
15-20 жил	9
Нийт хүний тоо	70

Төлөөллийг харахад энэ ажлыг сайн мэддэг, мэргэшиж дадсан хүмүүс болох нь харагдаж байна.


- Бид судалгааны үндсэн асуудлыг тавихын өмнө судалгаанд нийт хамрагдсан багш нарын мэргэжил сонголт, сонирхол, мэргэжлээр ажиллахад нөлөөлсөн зарим хүчин зүйлийг тодруулсан юм.
- 1. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн мэргэжил сонголт, мэргэжлээрээ ажиллаж буй байдал, сонирхол
- Энэ мэргэжлийг сонгох болсон шалтгааныг судлахад: Аав, ээж, найз нарын зөвлөснөөр 20-37,2%, сонирхлоороо 21-38,8%, тухайн үед буюу амьдралын шаардлагаар 11-20,3%, хариулт өгөөгүй 2-3,7% хүн байна

График 1.




- **Мөн мэргэжлээрээ ажиллахад нөлөөлсөн хүчин зүйлст:** Сонирхлынхоо дагуу 2-оо, мэргэжлийг эзэмшсэн учраас 15-27,8%, эцэг эх, найз нарын зөвлөснөөр 6-11, 10, хариулт өгөөгүй 6-11,1% хүн байгаа нь энэ мэргэжлийг сонгож ажилласан нөхцлийн 90 гаруй хувь нь /мэргэжлийн баримжаа өвлөх зорилгоор гэдгийг оруулаад эерэг сэдэл тэмүүлэл дээр суурилсан байгаа нь сайшаалтай.

График 2.



- **Ажил мэргэжилдээ сонирхолтой юу?** гэсэн асуултанд оролцогчдоос сонирхолтой 46-85,2%, сонирхолгүй 6-11,1%, тийм ч сонирхолтой биш 1-1,85%, хариулаагүй 1-1,85% хүн байна.


График 3.



2. **Багшийн ажлын байрны нөхцлийг дараах асуулгаар судалж үзэхэд:** Багшийн ажлын үргэлжлэх хугацааг ямар байна гэж бодож байна вэ? гэсэн асуултанд:
 - 10 цаг гэж 45 хүн - 83,3%
 - 8 цаг 5 хүн – 9,3%
 - 12 цаг 2 хүн - 3,7%


- Хариулт өгөөгүй 2 хүн - 3,7%

График 4.




- Багшийн ажлын ачааллыг юу гэж үздэг вэ? гэсэн асуултанд:
Их гэж 48 хүн — 88,9%,
Гайгүй 5 хүн - 9,3%,
хариулт өгөөгүй 1 хүн - 1,81%

График 5.



- Багшийн хөдөлмөр хамгаалалтанд хэрхэн ханддаг вэ?
Муу анхаардаг -27 – 50%
Боломжийн анхаардаг -11 - 20,3%
Дунд зэрэг -11 - 20,3%
Хариулт өгөөгүй -5 - 9,3%

График 6.




- Багшийн эрүүл мэндийг хамгаалах талаар хийгддэг ажил:
Тэр талаар хангалтгүй -28 — 50%

Хангалттай -6 - 11,1%

Үзлэгт хамруулж, эм тариагаар хангадаг -18 - 33,3%

Хариулт өгөөгүй -2 - 3,7%

График 7.



гэсэн дүн гарч байгаа нь талаас илүү хувь нь хангалтгүй гэсэн хариулт өгсөн нь багшийн ажлын хөдөлмөр хамгаалал, эрүүл мэндийн талаар болон хийж буй ажлын үр дүнг урамшуулах систем багш нарын сэтгэлд хүрэхгүй байгааг харуулж байна.

- **Багшийн ажилд нөлөөлдөг зүйлд:**

Амралт бага, чимээ шуугиан их -19 — 35,2%

Илүү цагаар ажилладаг, хөтөлдөг баримт бичиг их -20 — 37%

Ажиллах орчин муу, тохижилт хийхэд хөрөнгө мөнгө хангалтгүй -5 - 9,3%

Хариулт өгөөгүй -10 -18,5%

График 8.



- **Багшийн ажлын үр дүнг урамшуулах систем хангалттай эсэх, ямар хэлбэрээр гэдэг асуултанд:**

Төсөв байхгүй -20 — 37%

Ур чадвар илүү цаг авдаг -17 - 31,5%

Дунд зэрэг -11 - 20,4%

Хариулт өгөөгүй -6 - 11,1%

- **Багшийн боловсруулдаг, хөтөлдөг бичиг баримтын тоо, нэрийг дурдана уу? гэсэн асуултанд:**

Боловсруулж хөтөлдөг бичиг баримт их, конспект, үйл ажиллагааны төлөвлөлт, эрүүлжүүлэх судалгаа, хүүхдийн хөгжлийн судалгаа, эцэг эхийн хурлын материал, хэл ярианы судалгаа, Өдөр тутмын тэмдэглэх гэх мэт 20-40 хооронд гэсэн хариулт өгсөн байна.

- **Багшийн ажлыг үнэлж дүгнэдэг шалгалтын тоо, нэрийг дурдана уу?** гэсэн асуултанд:

Хүснэгт 9.

Хаанахын шалгалт	Хэдэн удаа
Аймаг, хотын мэргэжлийн хяналтын албаны шалгалт жилд	2 удаа
Боловсролын төвөөс жилд	4 удаа
Ариун цэврийн станц	Сар бүр
Нийгмийн бодлогын хэлтэс жилд	1 удаа
Байгууллагын болон эрхлэгчийн шалгалт	Сар бүр
Дүүргийн шалгалт	

Шалгалтууд их ирдэг нь ажлын ачааллыг ихэсгэдгээс гадна сэтгэл санааны хувьд дараа учруулдаг гэсэн хариултыг өгсөн байв.

Бид асуулгаар авсан судалгааны үр дүнг баталгаажуулах зорилгоор судалгаанд оролцоги доос ярилцлагын аргаар нэмэлт судалгаа авсан юм. Ярилцлагын үр дүнд цэцэрлэгүүдийн дунд зохион явуулдаг ар араасаа дагасан уралдаан, тэмцээнүүд хүүхэд хөгжүүлэхээсээ илүү багш хүүхдийг ядрааж, үйл ажиллагааг алдагдуулсан, хүүхдийг ялгаварлан, оролцоогүй үлдсэн хүүхдийн өөртөө итгэх итгэл, ХӨГЖлийг сааруулсан нөлөөллүүд давуу байгаа нь харагдлаа Эндээс багш нарын ачаалал их, ялангуяа багш нар хүүхэдтэйгээ ажиллах, тэднийг хөгжүүлэхэд зарцуулах цаг харьцангуй бага гэсэн дүгнэлтэнд хүргэлээ.

Дүгнэлт

Судалгааны үр дүнгээс дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Судалгаанд оролцсон багш нарын ихэнхи хувь нь ажилдаа дуртай, хэрэгцээ сонирхлынхоо дагуу мэргэжлээ сонгон ажиллаж байгаа, мөн эцэг эх, хүүхдийн хайр хүндэтгэлийг хүлээн эерэг энерги, сэтгэлийн ханамж авдаг явдал нь тогтвортой, идэвхи зүтгэлтэй ажиллах үндэслэл болж байна гэж тодорхойлж болох юм.
2. Цэцэрлэгийн үйл ажиллагааг хянаж шалгах бүх шатны байгууллагын хяналт шалгалтын тоо, хугацааг багшийн ажилд ачаалал, дарамт багатай зөвлөн тусалж байхаар зохион байгуулбал хүүхэд хөгжүүлэх ажлын үр дүн илүү байна гэж үзэж байна.
3. Хүүхэдтэй ажиллах арга барил, харилцаа, сургалт үйл ажиллагааг зохион байгуулах ур чадварыг дэлхийн чиг хандлагад нийцүүлэн явуулах чадварыг хот хөдөөгийн багш нарт тасралтгүй түгээх ажлыг нэмэгдүүлснээр багшийн хөгжил сайжирна.
4. Хүүхдүүдийн дунд явуулдаг уралдаан тэмцээнд бүх хүүхдийг жигд хамруулж, хүүхэд тус бүртэй хамтарч ажиллах нь тэдний ирээдүйд тодорхой хувь нэмэр оруулахын сацуу хүүхдэд өөртөө итгэх итгэлийг бий болгох юм.
5. Багшийн техник ажиллагаанд зарцуулах цагийг багасгаж, хүүхдүүдийн дунд явуулах үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэстэй нарийн төлөвлөж явуулбал хүүхэд хөгжүүлэхэд илүү цаг, боломж зарцуулж болохыг бидний судалгаа харууллаа.

Ашигласан материал

1. Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, технологийн салбарын статистикийн мэдээлэлийн эмхтгэл. /2004, 2004-2005 оны хичээлийн жил/ УБ. 2005 он.
2. Боловсрол судлал сэтгүүл УБ. 2004/04.
3. Гита Штейнер Хамси, Д.Түмэндэмбэрэл. Судалгаа хийх арга зүй УБ. 2005 он.
4. Б.Жадамба, Ц.Батсуурь. Чанартай боловсрол-Багшийн хөгжил УБ. 2001 он.
5. Д.Нямжав. Багш бэлтгэх тогтолцооны хөгжлийн зарим асуудал УБ. 2003 он.
6. Ц. Оюун. Багшийн хөгжлийн арга зүйн зарим асуудал УБ. 2003 он.
7. С.Санжаабадам. Боловсролын чанар ба Монголын хүний хөгжлийн хамаарал УБ. 2002 он.